

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь хүн амын өсөлтийг дэмжих зорилгоор хүүхэд, гэр бүлд тэтгэмж, хөнгөлөлт үзүүлэх, олон хүүхэдтэй эхийг урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хүн амын өсөлтийг дэмжих тухай хууль тогтоомж

2.1.Хүүхэд, гэр бүлд тэтгэмж, хөнгөлөлт үзүүлэх, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай, Гэр бүлийн тухай, Хөдөлмөрийн тухай, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж Гэр бүлийн тухай хуулийн 67.1.1-д заасны дагуу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон хүнийг;

3.1.2.“хүүхэд үрчлэн авах” гэж Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд үрчлэн авахыг;

3.1.3.“Алдарт эхийн I одон” гэж төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан, бага хүүхэд нь нэг нас хүрэхэд зургаа буюу түүнээс дээш тооны хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох урамшуулал;

3.1.4.“Алдарт эхийн II одон” гэж төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан, бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв буюу түүнээс дээш тооны хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох урамшуулал.

4 дүгээр зүйл.Хуулийн хамрах хүрээ

4.1.Энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан болзол, шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамрагдана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ, ХӨНГӨЛӨЛТ

5 дугаар зүйл.Тэтгэмж, шагнал, урамшуулал, хөнгөлөлтийн төрөл

5.1.Төрөөс олгох тэтгэмж дараах төрөлтэй байна:

- 5.1.1.жирэмсэн эхийн тэтгэмж;
- 5.1.2.хүүхдийн мөнгөн тэтгэмж;
- 5.1.3.ихэр хүүхдийн тэтгэмж.

5.2.Олон хүүхэдтэй эхэд олгох шагнал, урамшуулал нь дараах төрөлтэй байна:

- 5.2.1.Алдарт эх I, II одонгийн шагнал;
- 5.2.2.Алдарт эх I, II одонг дагалдах мөнгөн урамшуулал.

5.3.Олон хүүхэдтэй гэр бүлд үзүүлэх хөнгөлөлт нь дараах төрөлтэй байна:

- 5.3.1.татварын хөнгөлөлт;
- 5.3.2.орон сууцны хөнгөлөлт.

6 дугаар зүйл.Тэтгэмж, шагнал, урамшуулал, хөнгөлөлт олгохтой холбогдсон харилцаа

6.1.Жирэмсний таван сартайгаас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэлх хугацаанд эхэд сар бүр тэтгэмж олгоно.

6.2.0-16 хүртэлх насны хүүхдэд сар бүр хүүхдийн мөнгөн тэтгэмж олгоно.

6.3.Ихэр хүүхэд төрүүлсэн эхэд нэг удаа тэтгэмж олгоно.

6.4.Энэ хуулийн 5.2.1-д заасан шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгоно.

6.5.Алдарт эх I, II одонгоор шагнуулсан эхэд нэг удаа мөнгөн урамшуулал олгоно.

6.6.Дөрөв ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрхийн эх эсхүл эцэгт үзүүлэх татварын хөнгөлөлтийг Хувь хүний орлогын албан татварын хуулиар зохицуулна.

6.7.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон сууц барих аж ахуйн нэгжийн удирдлагатай тохиролцон шинээр баригдах орон сууцны дэд бүтцэд төсвөөс оруулсан хөрөнгө оруулалттай тэнцэх хэмжээний үнийн дүнтэй орон сууцыг тухайн орон нутгийн өмчлөлд авч, эхний ээлжид орон сууц шаардлагатай олон хүүхэдтэй гэр бүлд түрээслүүлэх, орон сууцны бага хүүтэй зээлд хамруулах, төлбөрийн уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах боломж бүрдүүлнэ.

6.8.Энэ хуулийн 5.1.1-д заасан тэтгэмжийг Нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсний тэтгэмж авах хугацаанд эхэд давхардуулан олгохгүй.

6.9.Тэтгэмж, хөнгөлөлтийг олгохдоо хууль ёсоор үрчлэн авсан, асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүүхдийг тухайн өрхийн хүүхдийн тоонд хамааруулан тооцно.

6.10.Хүүхдийн мөнгөн тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж авах эх, эцэг нас барсан эсхүл, тэжээн тэтгэхээс зайлсхийсэн бол хууль ёсны үрчлэн авсан эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгоно.

6.11.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн тодорхой хувийг хуримтлал хэлбэрээр хадгаламжийн дансанд хуримтлуулж, үлдсэн хувийг Хүүхэд хөгжлийн цахим картанд шилжүүлж тухайн хүүхдийн хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хүүхдийн хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зарцуулна.

6.12.Хүүхдийн мөнгөн тэтгэмжид нэг хүнд ногдох орлого, хэрэглээг үндэслэн амьжиргааны түвшний үзүүлэлтээр хүн амын хамгийн өндөр амьжиргаатай 20 хүртэлх хувьд байгаа өрх хамрагдахгүй.

6.13.Энэ зүйлийн 6.12-д заасан өрхийг тогтоох аргачлалыг Үндэсний Статистикийн хорооны дарга, санхүү төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.14.Энэ хуульд заасан тэтгэмж олгох журмыг Засгийн газар, шагнал, урамшуулал олгох журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тус тус батална.

7 дугаар зүйл.Тэтгэмж, урамшууллын хэмжээ

7.1.Энэ хуульд заасан тэтгэмж, урамшууллын хэмжээг Засгийн газар тогтооно.

7.2.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг өрхийн хүүхдийн тоо, нас, амьжиргааны түвшин болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-д заасан аюулт үзэгдэл, цар тахлын нөхцөл байдлыг харгалзан Засгийн газар ялгаатай тогтоож болно.

7.3.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 0-3 хүртэлх насны хүүхдэд Засгийн газраас тогтоосон хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж тооцож олгоно.

7.4.Тэтгэмжийн зардлыг хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсөвт, шагнал, урамшууллын зардлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөвт тус тус тусгаж, зарцуулах хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.5. Банк, санхүүгийн байгууллага энэ хуульд заасан тэтгэмжийг барьцаалан зээл олгохыг хориглоно.

7.6.Хүн амын өсөлт, амьжиргааг дэмжих чиглэлээр энэ хуульд зааснаас бусад хөтөлбөр, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэх тохиолдолд улс орны эдийн засгийн нөхцөл, төсвийн боломжид нийцүүлэн тухайн Засгийн газар зөвхөн бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

8 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт

8.1.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Алдарт эх I, II одонгоор шагнагдаж, жилд нэг удаа олгож байсан мөнгөн тусламж авах эрх үүссэн эхэд мөнгөн тусламжийг үргэлжлүүлэн олгоно.

8.2.Энэ зүйлийн 8.1-д заасан эх хүсэлт гаргасан тохиолдолд Алдарт эх I одонтой эхэд 2 сая төгрөг, Алдарт эх II одонтой эхэд 1 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгож, жилд нэг удаа олгож байсан мөнгөн тусламжийг олголтыг зогсооно.

9 дүгээр зүйл.Тэтгэмж, урамшууллаас суутгал хийх

9.1.Тэтгэмж, урамшуулал авагч хуурамч баримт бичиг бүрдүүлсний улмаас илүү олгогдсон тэтгэмж, урамшууллыг нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр, эсхүл улсын байцаагчийн шийдвэр гарсан бол суутгал хийнэ.

9.2.Суутгалын хэмжээ нь тухайн иргэний тэтгэмж, урамшууллын хэмжээний 50 хувиас хэтэрч болохгүй.

9.3.Энэ зүйлийн 9.1-т зааснаас бусад тохиолдолд иргэний тэтгэмж, урамшууллаас суутгал хийхийг хориглоно.

10 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

10.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

10.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

11 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

11.1.Энэ хуулийг 20... оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ